# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр Дугаар 770 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 4,868,115.00 (дөрвөн сая найман зуун жаран найман мянга нэг зуун арван таван) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Авто баазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 33,229,500.00 (гучин гурван сая хоёр зуун хорин есөн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 26,886,822.94 (хорин зургаан сая найман зуун наян зургаан мянга найман зуун хорин хоёр хоёр төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч 2 дугаар хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Хэнтий, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2.Хавсралтад заасан хөрөнгө (автомашин)-ийг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

1320171

3.4.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын нэр дээрх тээврийн хэрэгсэлийг улсын бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
770 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, марк | Ашиглалтанд орсон огноо | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Тоо хэмжээ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| Нэг. НХЖХОНАБХА-НЫ ЭРГҮҮЛ ХАМГААЛАЛТЫН ГАЗАР | | | | | |
| 1 | Мотоцикл /policy, эхг, ху 150-3/ | 9/3/2009 | 1,200,000.00 | 4.00 | 4,800,000.00 |
| Дүн | | | | 4.00 | 4,800,000.00 |
| Хоёр.ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ | | | | | |
| 1 | Мотоцикл | 7/1/1985 | 68,115.00 | 1.00 | 68,115.00 |
| Дүн | | | | 1.00 | 68,115.00 |
| НИЙТ ДҮН | | | | | 4,868,115.00 (дөрвөн сая найман зуун жаран найман мянга нэг зуун арван таван) |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн
770 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТО БААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, марк | Ашиглалтад орсон огноо | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын нийт үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Шилжүүлэн авах хуулийн этгээд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хьюндай элентра, 09-26 УНҮ, (KMHDT41BABU247478) | 2014.08.26 | 22,990,000.00 | ширхэг | 1.00 | 22,990,000.00 | 22,990,000.00 | - | Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар |
| 2 | Хьюндай соната-7, 09-41 УНҮ (KMHEB41BACA494127) | 2019.12.29 | 7,150,000.00 | ширхэг | 1.00 | 7,150,000.00 | 3,575,000.04 | 3,574,999.96 | |
| 3 | Мотоцикл, ямаха (YD110, ME1UE2425J3004332) | 2020.08.05 | 3,089,500.00 | ширхэг | 1.00 | 3,089,500.00 | 321,822.90 | 2,767,677.10 | Төв аймаг дахь Цагдаагийн газар (Алтанбулаг сум) |
| Нийт дүн | | | | | | 33,229,500.00 (гучин гурван сая хоёр зуун хорин есөн мянга таван зуун) | 26,886,822.94 (хорин зургаан сая найман зуун наян зургаан мянга найман зуун хорин хоёр хоёр төгрөг ерэн дөрвөн мөнгө) | 6,342,677.06 (зургаан сая гурван зуун дөчин хоёр мянга зургаан зуун далан долоон төгрөг зургаан) | |